



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/203

Алтай хот

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/87 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Аймгийн хэмжээнд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн 25 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2.Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад орон нутгийн төр захиргааны байгууллагууд, малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжийг татан оролцуулж, ажиллах хүч, хашаа хороо, тээврийн хэрэгсэл бусад шаардлагатай асуудлыг шуурхай шийдвэрлэн тогтоосон хугацаанд үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Вакцин биобэлдмэл, халдвар хамгааллын хувцас, халдваргүйтгэлийн бодисыг хугацаанд нь татан авч хуваарилах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Д.Наянбуу)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР